



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/17/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТУБ	Татварын улсын байцаагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Д.С. Д.С.

№

53

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал, татварын улсын байцаагчийн ажлын үр дүнгээр мөнгөн шагнал тус тус тооцож олгосон байхад оны эцэст газрын даргын тушаалаар 44 албан хаагчид 76,913.8 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал давхардуулан олгосон, татварын улсын байцаагчийн эрх олгогдоогүй байхад 2,101.6 мянган төгрөгийн ТУБ-ийн үр дүнгийн урамшил олгосон, нягтлан бодогчид 1,452.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон, мөнгөн шагнал 1,757.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон зэрэг төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчлүүд цалингийн зардлын дансанд илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2, Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам"-ын 1.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4525020174

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд батлагдсан төсвөөс Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангийн харилцах дансанд 46,217.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, санхүүгийн тайланд тодруулж толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 36.9 хувиар буюу 656,687.7 мянган төгрөгөөр, 2024 оны 83 дугаар тогтоолоор орон нутагт тогтвор, суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид тэтгэмж олгож эхэлснээр хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардалд 173,520.5 мянган төгрөг төлөвлөж, 97.7 хувийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Татварын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР




2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,369,589.71	161,191,296.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,136,465.00	84,498,063.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	62,136,465.00	84,498,063.00
3121	Төгрөг	62,136,465.00	84,498,063.00
31211	Төрийн сангийн харилцах	62,136,465.00	84,498,063.00
33	АВЛАГА	-	116,742.43
335	Бусад авлага	-	116,742.43
3351	Байгууллагаас авах авлага	-	116,742.43
35	БАРАА МАТЕРИАЛ	75,233,124.71	76,576,490.91
354	Хангамжийн материал	75,233,124.71	76,576,490.91
35410	Бичиг хэргийн материал	7,208,253.60	7,519,063.60
35420	Аж ахуйн материал	16,985,977.00	17,645,608.00
35440	Түлш, шатах тослох материал	1,160,000.00	1,050,000.00
35450	Барилгын засварын материал	1,573,500.00	1,971,000.00
35470	Бусад хангамжийн материал	48,305,394.11	48,390,819.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,093,461,861.60	1,034,583,446.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,093,461,861.60	1,034,583,446.64
392	Биет хөрөнгө	782,461,861.60	723,583,446.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	855,934,529.00	855,934,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(212,985,563.04)	(251,024,795.82)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,500,000.00	36,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,358,348.78)	(33,452,783.14)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	263,598,704.72	308,647,704.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,797,368.34)	(232,753,855.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,364,527.23	25,654,527.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,945,720.13)	(12,233,527.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,126,868.00	64,126,868.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30,975,767.06)	(37,815,220.04)
393	Биет бус хөрөнгө	311,000,000.00	311,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	311,000,000.00	311,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,230,831,451.31	1,195,774,742.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,230,831,451.31	1,195,774,742.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,230,831,451.31	1,195,774,742.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	820,279,777.00	820,279,777.00
51101	Өмч: - төрийн	820,279,777.00	820,279,777.00
512	Хуримтлагдсан үр дүн	(270,959,561.36)	(306,016,269.69)
51210	Өмнөх үеийн үр дүн	(223,117,834.04)	(270,959,561.36)
51220	Тайлант үеийн үр дүн	(47,841,727.32)	(35,056,708.33)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	681,511,235.67	681,511,235.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,230,831,451.31	1,195,774,742.98



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,993,369,341.83	2,834,155,380.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,950,091.83	45,449,080.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,950,091.83	45,449,080.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	34,950,091.83	45,414,080.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33,400,328.23	45,049,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,549,763.60	365,080.00
120009	Бусад орлого	-	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,958,419,250.00	2,788,706,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,816,174,400.00	2,448,703,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,816,174,400.00	2,448,703,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,244,850.00	340,002,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,244,850.00	340,002,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,041,211,069.15	2,869,212,088.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,041,211,069.15	2,869,212,088.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,926,055,118.83	2,630,977,264.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,473,193,335.84	2,015,919,188.40
210101	Үндсэн цалин	673,441,864.21	906,770,560.11
210102	Нэмэгдэл цалин	401,975,993.36	649,145,221.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,640,000.00	80,536,503.31
210104	Урамшуулал	327,135,478.27	379,466,903.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,496,325.82	254,228,350.74
210201	Тэтгэврийн даатгал	129,831,150.54	174,527,890.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,609,971.85	20,591,234.12
210203	ҮОМШ өвчний даатгал	11,406,377.50	10,057,251.15
210204	Ажилгүйдлын даатгал	2,785,150.75	9,805,629.06
210205	Эрүүл мэндийн даатгал	27,863,675.18	39,246,346.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,491,530.26	21,377,888.85
210301	Гэрэл цахилгаан	6,464,050.84	8,378,575.65
210302	Түлш, халаалт	9,864,122.84	10,383,916.96
210303	Цэвэр, бохир ус	2,163,356.58	2,615,396.24
2104	Хангамж, бараа материалын зардал	27,213,846.70	28,705,022.20
210401	Бичиг хэрэг	13,847,395.30	8,050,600.00
210402	Тээвэр шатахуун	7,850,000.00	11,290,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,499,938.40	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	156,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,821,513.00	6,707,922.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,730,660.00	49,831,421.60
210601	Багаж, техник хэрэгсэл	-	2,354,000.00
210604	Урсгал засвар	16,730,660.00	47,477,421.60
2107	Томилолт, зочны зардал	3,900,800.00	20,625,500.00
210702	Дотоод албан томилолт	3,900,800.00	20,625,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,537,918.00	68,806,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,651,440.00	66,847,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,041,700.00	903,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,174.00	105,174.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	676,024.00	894,964.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,580.00	12,320.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,490,702.21	171,483,214.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,725,000.00	56,254,800.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	3,011,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	118,765,702.21	112,217,414.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,155,950.32	238,234,823.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,533,085.00	221,128,949.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,171,085.00	40,735,236.00
213208	ХОН-т тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	169,493,713.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,362,000.00	10,900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,622,865.32	17,105,874.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,097,010.58	13,938,709.23
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	525,854.74	3,167,164.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(47,841,727.32)	(35,056,708.33)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(47,841,727.32)	(35,056,708.33)




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,001,634,322.00	2,834,923,898.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,215,072.00	46,217,598.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,215,072.00	46,217,598.00
120009	Бусад орлого	43,215,072.00	46,217,598.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,958,419,250.00	2,788,706,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,816,174,400.00	2,448,703,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,816,174,400.00	2,448,703,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,244,850.00	340,002,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,244,850.00	340,002,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,969,589,250.00	2,804,272,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,969,589,250.00	2,804,272,300.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,854,433,299.68	2,566,037,476.42
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,516,408,407.84	2,062,243,918.33
210101	Үндсэн цалин	714,785,818.73	906,770,560.11
210102	Нэмэгдэл	403,847,110.84	695,469,951.79
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	70,640,000.00	80,536,503.31
210104	Урамшуулал	327,135,478.27	379,466,903.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,496,325.82	254,237,961.24
210201	Тэтгэврийн даатгал	129,831,150.54	174,644,632.43
210202	Тэтгэмжийн даатгал	14,609,971.85	20,484,102.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,406,377.50	10,057,251.15
210204	Ажилгүйдлийн даатгал	2,785,150.75	9,805,629.06
210205	Эрүүл мэндийн даатгал	27,863,675.18	39,246,346.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,491,530.26	21,377,888.85
210301	Гэрэл, цахилгаан	6,464,050.84	7,527,270.81
210302	Түлш, халаалт	9,864,122.84	11,235,221.80
210303	Цэвэр, бохир ус	2,163,356.58	2,615,396.24
2104	Хангамж, бараа материалын зардал	18,186,237.76	25,525,000.00
210401	Бичиг хэрэг	4,161,000.00	6,080,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,950,000.00	11,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,989,537.76	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,890,700.00	5,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,395,160.00	49,211,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,354,000.00
210604	Урсгал засвар	16,395,160.00	46,857,050.00
2107	Томилолт, зочны зардал	3,900,800.00	20,625,500.00
210702	Дотоод албан томилолт	3,900,800.00	20,625,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,336,338.00	68,979,358.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,469,440.00	67,032,020.00



210803	Даатгалын үйлчилгээ	1,041,700.00	903,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,174.00	105,174.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	676,024.00	894,964.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,218,500.00	63,836,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,218,500.00	55,136,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	8,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,155,950.32	238,234,823.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,533,085.00	221,128,949.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,171,085.00	40,735,236.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	169,493,713.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,362,000.00	10,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	525,854.74	3,167,164.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	525,854.74	3,167,164.85
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,097,010.58	13,938,709.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,097,010.58	13,938,709.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	32,045,072.00	30,651,598.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,290,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,290,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,290,000.00
223001	Бусад хөрөнгө	-	8,290,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(8,290,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	32,045,072.00	22,361,598.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,091,393.00	62,136,465.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,136,465.00	84,498,063.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	(223,117,834.04)		1,278,673,178.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	(223,117,834.04)		1,278,673,178.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			(47,841,727.32)		(47,841,727.32)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	(270,959,561.36)		1,230,831,451.31
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	(270,959,561.36)		1,230,831,451.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			(35,056,708.33)		(35,056,708.33)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	(306,016,269.69)		1,195,774,742.98




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,810,251,200.00	1,809,171,342.82	(1,079,857.18)	99.9
210101	Үндсэн цалин	810,585,100.00	906,770,560.11	96,185,460.11	111.9
210102	Нэмэгдэл цалин	443,778,300.00	442,397,376.28	(1,380,923.72)	99.7
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	87,597,300.00	80,536,503.31	(7,060,796.69)	91.9
210104	Урамшуулал	468,290,500.00	379,466,903.12	(88,823,596.88)	81.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,269,100.00	222,750,001.60	(8,519,098.40)	96.3
210201	Тэтгэврийн даатгал	162,062,900.00	153,133,463.51	(8,929,436.49)	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	17,301,500.00	17,954,538.01	653,038.01	103.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,650,800.00	8,792,469.11	141,669.11	101.6
210204	Ажилгүйдлийн даатгал	8,650,800.00	8,569,604.82	(81,195.18)	99.1
210205	Эрүүл мэндийн даатгал	34,603,100.00	34,299,926.15	(303,173.85)	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,508,600.00	21,377,888.85	(130,711.15)	99.4
210301	Гэрэл, цахилгаан	7,266,300.00	7,527,270.81	260,970.81	103.6
210302	Түлш, халаалт	11,742,300.00	11,235,221.80	(507,078.20)	95.7
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,615,396.24	115,396.24	104.6
2104	Хангамж, бараа материалын зардал	22,125,000.00	22,125,000.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	6,080,000.00	6,080,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,600,000.00	8,100,000.00	500,000.00	106.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,500,000.00	(500,000.00)	83.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	195,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,250,000.00	5,250,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,511,100.00	47,507,050.00	(4,050.00)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	650,000.00	650,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	46,861,100.00	46,857,050.00	(4,050.00)	100.0
2107	Томилолт, зочны зардал	20,630,000.00	20,625,500.00	(4,500.00)	100.0
210702	Дотоод албан томилолт	20,630,000.00	20,625,500.00	(4,500.00)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,153,000.00	68,979,358.00	(173,642.00)	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,056,000.00	67,032,020.00	(23,980.00)	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,041,700.00	903,200.00	(138,500.00)	86.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,200.00	105,174.00	(26.00)	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	906,100.00	894,964.00	(11,136.00)	98.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000.00	8,700,000.00	-	100.0

ХТ05430/99022399

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	8,700,000.00	8,700,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	217,555,800.00	213,528,949.50	(4,026,850.50)	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	217,555,800.00	213,528,949.50	(4,026,850.50)	98.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,735,300.00	40,735,236.00	(64.00)	100.0
213208	ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	173,520,500.00	169,493,713.50	(4,026,786.50)	97.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,448,703,800.00	2,434,765,090.77	(13,938,709.23)	99.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	50	47	3	94.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	44	41	3	93.2
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0
620004	Гэрээт ажилтан				



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	336,835,335.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,835,335.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,835,335.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,072,575.51
210102	Нэмэгдэл	253,072,575.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,487,959.64
210201	Тэтгэврийн даатгал	21,511,168.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,529,564.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,264,782.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,236,024.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,946,420.26
2104	Хангамж, бараа материалын зардал	3,400,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,994,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,994,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,880,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,880,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	336,835,335.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	336,835,335.15
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	336,835,335.15
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Татварын газар нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд “Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино” эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТЕГ-ын даргын 2020 оны А/156 дугаар тушаалаар баталж, мөн оны 11 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,195,774.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	62,136.4	84,498.0	22,361.6
Авлага	-	116.7	116.7
Бараа материал	75,233.1	76,576.5	1,343.4
Үндсэн хөрөнгө	1,093,461.9	1,034,583.5	(58,878.4)
Нийт хөрөнгө	1,230,831.4	1,195,774.7	(35,056.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,230,831.4	1,195,774.7	(35,056.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,230,831.4	1,195,774.7	(35,056.7)

Мөнгөн хөрөнгийн 84,498.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 116.7 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шийтгэлийн илүү төлөлт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,343.4 мянган төгрөгөөр өсөхөд төсвийн хөрөнгөөр 83,423.0 мянган төгрөгийн материал худалдан авч, үйл ажиллагаандаа 82,079.7 мянган төгрөгийн материал зарцуулсан нь нөлөөлжээ. Бараа материалын дансанд үйл ажиллагаатай холбоотой шилэн кабель, сүлжээний утас, аж ахуйн материал, бичиг хэргийн материал голлох үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгийн дансны бууралт нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,290.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ТӨБЗГ-ын 2024 оны А1/1772, А1/2405 дугаар тогтоолуудаар 45,049.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан, 112,217.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо данс 35,056.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,610,329.7 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 233,096.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,843,426.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 605,277.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 2,448,703.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс болон жилийн эцсийн мөнгөн урамшуулалтай холбоотойгоор цалингийн зардлыг 308,360.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 173,520.5 мянган төгрөг, тэтгэвэрт

гарсан албан хаагчийн урамшууллыг 40,735.3 мянган төгрөг, бусад зардлыг 82,661.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх 2,448,703.8 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,448,703.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 2,434,765.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 13,938.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	70205-Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	2,448,703.8	2,434,765.0	(13,938.8)	99.4
1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	2,164,092.0	2,154,204.1	(9,887.9)	99.5
1.2	80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	1,500.0	1,500.0	-	100.0
1.3	80219-Харуул, хамгаалалтын зардал	43,200.0	43,200.0	-	100.0
1.4	80220-Холбооны суваг ашигласны хөлс	22,356.0	22,332.0	(24.0)	99.9
1.5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	217,555.8	213,528.9	(4,026.9)	98.1
Нийт дүн		2,448,703.8	2,434,765.0	(13,938.8)	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тайлант онд 43,200.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 тендер шалгаруулалтыг хуульд заасны дагуу зохион байгуулж, цахим системд үр дүнг тайлагнасан байна.

Тус газар батлагдсан төсвөөс Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангийн харилцах дансанд 46,217.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Мөн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 67,032.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 52,111.7 мянган төгрөг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд ТЕГ-ын даргын 2024 оны А/04 тоот тушаалаар нийт 50 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 3 орон тоо дутуу ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн захирагчид дээд шатны төсвийн захирагчаас төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдлийн санхүүжилт 284,535.3 мянган төгрөг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар хураалтын үйл ажиллагааны зардал 30,500.0 мянган төгрөг, татвар төлөгчдийн өдөрлөгт 10,600.0 мянган төгрөг, Эрүүл аюулгүй ажлын байр төслийн санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, татвар хураалтын шатахууны зардалд 1,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 3,167.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд харьцуулалтын аргаар харуул хамгаалалтын үйлчилгээний 43,200.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын цалин, нэмэгдэл хөлсний зардалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Н.Отгонцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 39 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,448,703.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,487.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал, татварын улсын байцаагчийн ажлын үр дүнгээр мөнгөн шагнал тус тус тооцож олгосон байхад оны эцэст газрын даргын тушаалаар 44 албан хаагчид 76,913,813.00 төгрөгийн мөнгөн урамшуулал давхардуулан олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 26,931.0 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 78,954.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжилтийг тулган шалгахад 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	78,954.9	1	78,954.9	100.0
Нийт дүн	1	78,954.9	1	78,954.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Татварын ерөнхий газрын 2023 оны А/36, 2024 оны А/04 дүгээр тушаалаар Татварын газрын орон тоог батлахдаа нягтлан бодогчийн албан тушаалын зэрэглэлийг ТЗ-7 ангиллаар баталсан, боловч албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулаагүй ТЗ-6 ангиллаар баталсан байна.

2. "Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам"-д татварын улсын байцаагчийн эрхтэй, татварын улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчаас бусад албан хаагч авах эсэх нь тодорхой тусгаагүй байна.

Мөн ТЕГ-ын даргын шийдвэргүйгээр аймгийн Татварын газрын даргад ТУБ-ийн үр дүнгийн урамшуулал олгож байгаа бөгөөд татварын улсын байцаагчийн эрхтэй нягтлан бодогч тус урамшууллыг сар бүр авч байна.

3. Тайлант онд төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал, татварын улсын байцаагчийн ажлын үр дүнгээр мөнгөн шагнал тус тус тооцож олгосон байхад оны эцэст газрын даргын тушаалаар 44 албан хаагчид 76,913,813.00 төгрөгийн мөнгөн урамшуулал давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд 190.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг тусгаагүй алдаа¹ илэрсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгүүлж залруулав.

Мөн аудитаар нийт 82,224.4 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 2 төлбөрийн акт, 5 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Татварын улсын байцаагчийн эрх олгогдоогүй байхад 2,101.6 мянган төгрөгийн ТУБ-ийн үр дүнгийн урамшил олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, ТЕГ-ын даргын 2022 оны А/105 тоот тушаалаар баталсан "Татварын албаны хүний нөөц бүрдүүлэлтийн журам"-ын 8.3 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

2. Байгууллагын нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,452.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоож аудитын явцад барагдуулсан болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд орон нутаг дахь төрийн байгууллагуудаа манлайлан, үйл ажиллагааны үр дүнгээрээ тэргүүлсэн тул байгууллагын даргад аймгийн Засаг даргын захирамжаар 1,757.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т заасныг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлын ангиллаас зарцуулах

1.2. Илрүүлэлт:

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохдоо байгууллагын хүний нөөцийн ажилтны тодорхойлолт, төсвийн шууд захирагчийн тушаалтай зөрүүтэй олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь заалтын дагуу төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг төсөв захирагчийн шийдвэр, хүний нөөцийн цахим системд үндэслэн олгох

1.3. Илрүүлэлт:

Албан хаагчдын хоол, унааны мөнгийг хөдөлмөрийн дотоод журамд зааснаас 16,623.0 мянган төгрөгөөр дутуу олгосон нь Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 7 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.3-т заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 7 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.3 дахь заалтыг баримталж хоол, унааны хөнгөлөлтийг олгож байх

1.4. Илрүүлэлт:

Тайлант онд төрийн албан хаагчийн улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал, татварын улсын байцаагчийн ажлын үр дүнгээр мөнгөн шагнал тус тус тооцож олгосон байхад оны эцэст газрын даргын тушаалаар 44 албан хаагчид 76,913,813.00 төгрөгийн мөнгөн урамшуулал давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2, Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам"-ын 1.2 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгох журам"-ын 1.2-т "Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагнал нь тухайн албан хаагчийн албан

тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг баримталж мөнгөн урамшууллыг хэтрүүлэн олгохгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ .Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 190.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй	1	190.0	1	190.0	-	-	1	190.0	-	-	-	-	-	-
Дүн	1	190.0	1	190.0	-	-	1	190.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тайлбар
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжаар 1,757,000 төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардаас олгосон байна.	1	1,757.0	-	-	-	-	1	1,757.0	-	-	
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохдоо байгууллагын хүний нөөцийн ажилтан тодорхойлолт, төсвийн шууд захирагчийн тушаалтай зөрүүтэй олгосон байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	
Албан хаагчдын хоол, унааны мөнгийг хөдөлмөрийн дотоод журамд зааснаас сар бүр зөрүүтэй олгосон байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	
Татварын улсын байцаагчийн эрх олгогдоогүй байхад 2,101.6 мянган төгрөгийн ТУБ-ийн үр дүнгийн урамшил олгосон байна.	1	2,101.6	1	2,101.6	-	-	-	-	-	-	Аудитын явцад барагдуулсан.
Байгууллагын нягтлан бодогчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,452.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	1,452.0	1	1,452.0	-	-	-	-	-	-	Аудитын явцад барагдуулсан.
Тайлант онд тус байгууллагын 44 албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, ТУБ-ийн сар бүрийн үр дүнгийн мөнгөн шагналтай давхардуулан 76,913.8 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	76,913.8	-	-	-	-	1	76,913.8	-	-	
Дүн	6	82,224.4	2	3,553.6	-	-	4	78,670.8	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс	
	Тоо	Н/Д	Тоо	Н/Д	Тоо	Н/Д	Тоо	Зөвлөмж
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 26,931,000 төгрөгийн 5 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-